



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/395

Булган сум

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.3.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн “Алтаргана-2024” наадмыг зохион байгуулах ажлын хүрээнд “Миний мэдэх Буриад зон” эссэ бичлэг болон ном бүтээх уралдааныг тус тус зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т үүрэг болгосугай.

2. Уралдааныг зохион байгуулахад шаардагдах 2,440,000 (хоёр сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийг Дэлхийн “Алтаргана-2024” наадмын бэлтгэл ажлыг хангах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б. АРИУН-ЭРДЭНЭ